



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2016 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2016 оныг “Ажил олгогч, даатгуулагчийг  
дэмжих жил” болгон зарлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн “гурав”-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу ажил олгогч, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх зорилгоор нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2016 оныг “Ажил олгогч, даатгуулагчийг дэмжих жил” болгон зарласугай.

2. Ажил олгогч, даатгуулагчийг дэмжих жилийн хүрээнд 2016 онд хийх ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх, ажлын явц, үр дүнг Газрын даргад улирал бүр танилцуулж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газар (Б.Батбаатар)-т, энэ төлөвлөгөөнд үндэслэн дэд ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлж ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээний газар (М.Энхтуяа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МЭНДБАЯР

1000004